



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 07 сарын 08 өдөр

Дугаар А/373

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай Монгол улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 10/06 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Замын сангийн хөрөнгө оруулалтаар “Төвлөрсөн хогийн цэгт хог отволдож дарж зам гаргах ажил”-ын хүрээнд 5, 6, 7 дугаар сард зарцуулах зардалд зориулан 9 650 000 төгрөгийг зарцуулсугай.


2. Дээрх арга хэмжээнд зарцуулагдах 9 650 000 төгрөг /есөн сая зургаан зуун тавин мянга/-ийг аймгийн Замын сангийн 4.9-д тусгагдсан арга хэмжээнээс санхүүжүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/ нарт зөвшөөрсүгэй.

3. “Төвлөрсөн хогийн цэгт хог отволдож дарж зам гаргах ажил”-ын хүрээнд зарцуулах зардлыг хавсралтаар баталсугай.


4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ



Аймгийн Засаг даргын 2020 оны
07 дугаар сарын 08-ны өдрийн
А/373 дугаар захирамжийн хавсралт.



“ТӨВЛӨРСӨН ХОГИЙН ЦЭГТ ХОГ ОТВОЛДОЖ ДАРЖ
ЗАМ ГАРГАХ АЖИЛ”-ИЙН ХҮРЭЭНД ЗАРЦУУЛАХ ЗАРДАЛ

Д/д	Зардлын төрөл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ /90 хоног/	Нэгж үнэ /төгрөг/	Нийт үнэ /төгрөг/
1.	Хогийн цэгт ажиллах шатахууны зардал	л	3600	1750	6 300 000
2.	Тос, масло, сэлбэг	багц	1	2000000	2 000 000
3.	Хөдөлмөр хамгааллын зардал	Хүн/өдөр	90	5000	450 000
4.	Жолоочид урамшуулал, хоолны зардал	Хүн/өдөр	90	10000	900 000
	Нийт				9 650 000

-oOo-